

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/175/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Аудитор : Д.Номингуа Утас: 51-261885 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn Аккаунт траст аудит ХХК-ийн захирал: П.Наранцэцэг Цахим хаяг: acctrust.audit@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	17
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	18
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	18
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	18
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	19
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	20
3.5.1 Төсвийн төлөвлөлт	20
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	21
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	22
4. АУДИТЫН ТАЙЛАН	22
4.1 Ерөнхий зүйл.....	22
4.2 Материаллаг байдал	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.5.1 Завсрын аудитын талаар	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	25
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	26
5.2 Албан шаардлага	26
5.3 Зөвлөмж.....	29
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	31

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.05 № 06/5 20
танай _____-ны № _____-т

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ
ЦОГЦОЛБОРЫН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Б.ОТГОНБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,137,976.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Хүнсний бараа, материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцогчоос багцыг гүйцэтгэхээр ирүүлсэн саналын үнэ нь тендерийн нээлтэд зарлагдсан үнийн саналаас бага байгааг хэрхэн шийдвэрлэсэн талаар Үнэлгээний хороо нь тайлбар тодруулга, залруулга хийхгүйгээр 21,441.0 мянган төгрөгийн илүү дүнгээр гэрээг байгуулсан;
- Нээлттэй тендер шалгаруулалтаар шалгарсан 5 аж ахуйн нэгжээс гэрээний үнийн дүнгийн 20 хувиас илүү 106,994.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн.
- Олон жил болсон 148,160.7 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, тайлант онд бэлтгэн нийлүүлэгч болон татвар, нийгмийн даатгалд нийт 50,912.6 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.2.2, 36 дугаар зүйлийн 36.1.3, 39 дүгээр зүйлийн 39.1, 40 дүгээр зүйлийн 40.2, 40.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "оршин байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Засгийн газрын нөөц сангийн 1,447,856.0 мянган төгрөгийн санхүүжилтээр Хараацай театрын барилга, Хөгжил мэдээллийн ордон, 3 бүлгийн ариун цэврийн өрөөнд, үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос 241,473.8 мянган төгрөгийн их засварыг тус тус хийж, нийт 1,689,329.8 мянган төгрөгийн барилгын сайжруулалтыг бүртгэжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны авлага 336,669.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 29,520.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 9,500.0 мянган төгрөг, нийт 375,689.1 мянган төгрөгийг бүрдүүлж, гүйцэтгэлээр хангамж, бараа материалын зардалд 4,320.0 мянган төгрөг, нормативт зардалд 25,200.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 289,213.8 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 16,200.0 мянган төгрөг, нийт 334,933.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 40,755.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Бусад асуудал

Тайлант онд 47 үндсэн ээлж хүлээн авч хөгжлийн хөтөлбөрийг давхардсан тоогоор 170 гаруй удаа зохион байгуулсан, мөн "Lego steam lab"-ийг ашиглалтад оруулж, 670 гаруй амрагч хамрагдсан байна.

Физик элементүүдийг бодит байдалтай хослуулсан өвөрмөц сургалтын AR орчин, виртуал аялал хийж, бодит амьдрал дээр очиж чадахгүй газруудыг судлах боломжтой VR орчин, шинжлэх ухааны гайхамшиг, технологийн дэвшилд суралцаж шинийг сэдэж, бүтээлч сэтгэхүйг нь хөгжүүлэх Стим робот гэсэн үндсэн чиглэлтэй "Лего робот хөтөлбөр"-ийг шинээр хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б. А. Ц. НАРАНЧИМЭГ*



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,671,499,364.97	1,819,722,102.80
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	36,000,000.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	36,000,000.00	0.00
3121	Төгрөг	36,000,000.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
31216	Нэмэлт санхүүжилт арилжааны банк	36,000,000.00	-
33	АВЛАГА	548,859,756.99	358,090,582.08
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	15,198,604.79	16,080,063.27
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	134,480,800.00	148,642,300.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	-	89,425,332.00
335	Бусад авлага	399,180,352.20	103,942,886.81
3351	Байгууллагаас авах авлага	399,180,352.20	103,942,886.81
35	БАРАА МАТЕРИАЛ	1,086,639,607.98	1,461,631,520.72
351	Түүхий эд материал	883,013.80	2,120,198.45
35130	Эм боох материал	883,013.80	2,120,198.45
354	Хангамжийн материал	1,085,756,594.18	1,459,511,322.27
35420	Аж ахуйн материал	243,479,998.77	468,571,475.47
35430	Сэлбэг хэрэгсэл	3,185,000.00	10,629,000.00
35440	Түлш шатах тослох материал	3,750,400.00	7,068,692.00
35460	Хүнсний материал	24,052,040.55	19,352,088.80
35470	Бусад хангамжийн материал	811,289,154.86	953,890,066.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	22,185,280,860.69	22,349,143,744.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	22,185,280,860.69	22,349,143,744.15
392	Биет хөрөнгө	22,019,623,352.31	22,159,796,110.70
39201	Барилга, байгууламж	21,102,794,108.50	22,792,123,918.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,962,884,511.24)	(3,898,959,966.57)
39203	Авто тээврийн хэрэгсэл	869,677,276.73	869,677,276.73
39204	Хуримтлагдсан элэгдэл	(469,772,976.31)	(556,639,676.23)
39205	Машин, тоног төхөөрөмж	3,889,983,737.50	4,039,355,676.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,094,208,516.43)	(1,637,769,057.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,094,623,230.54	934,436,342.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	(629,511,103.06)	(541,717,248.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	594,812,943.53	594,812,943.53
39215	Хуримтлагдсан элэгдэл	(375,890,837.45)	(435,524,099.01)
393	Биет бус хөрөнгө	165,657,508.38	189,347,633.45
39301	Програм хангамж	8,362,000.00	37,501,500.00
39302	Хасагдуулга	(5,666,125.00)	(10,115,499.97)
39303	Бусад биет бус хөрөнгө	179,128,300.00	179,128,300.00
39304	Хасагдуулга	(16,166,666.62)	(17,166,666.58)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	23,856,780,225.66	24,168,865,846.95
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	164,954,602.19	98,459,960.57
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	164,954,602.19	98,459,960.57
413	Өглөг	164,954,602.19	22,394,860.57
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	(0.00)	879,413.47

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	157,041,620.19	20,629,094.10
4136	Бусад өглөг	7,912,982.00	886,353.00
41361	Байгууллагад төлөх өглөг	6,997,284.00	597,000.00
41362	Хувь хүмүст төлөх өглөг	915,698.00	289,353.00
414	Урьдчилж орсон орлого	-	76,065,100.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	-	76,065,100.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	23,691,825,623.47	24,070,405,886.38
51	Засгийн газрын хувь оролцоо	23,691,825,623.47	24,070,405,886.38
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	6,207,582,556.84	6,207,582,556.84
51101	Өмч: -Төрийн өмч	6,207,582,556.84	6,207,582,556.84
512	Хуримтлагдсан үр дүн	5,877,079,420.57	6,255,659,683.48
51210	Өмнөх үеийн үр дүн	(3,981,625,472.97)	5,877,079,420.57
51220	Тайлант үеийн үр дүн	9,858,704,893.54	378,580,262.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,607,163,646.06	11,607,163,646.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	23,856,780,225.66	24,168,865,846.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	20,071,069,227.01	11,891,641,867.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,960,936,805.01	11,891,641,867.76
120	Нийтлэг татварын бус орлого	15,960,936,805.01	8,631,135,467.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,474,133,751.01	7,056,140,722.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,300,133,751.01	6,882,140,722.76
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	174,000,000.00	174,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,481,896,576.00	1,551,997,145.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,906,478.00	22,997,600.00
122	Тусламжийн орлого	-	3,260,506,400.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	3,260,506,400.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	3,221,486,400.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	3,221,486,400.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	39,020,000.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	39,020,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,110,132,422.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,025,056,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,025,056,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,085,075,722.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	411,737,000.00	-

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	673,338,722.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,211,221,570.34	11,513,061,604.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,211,221,570.34	11,513,061,604.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,037,015,390.41	11,425,833,043.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,991,163,863.65	4,644,751,697.29
210101	Үндсэн цалин	1,939,389,432.72	2,172,452,344.67
210102	Нэмэгдэл	1,106,843,050.39	1,166,567,199.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	443,815,000.00	795,246,535.41
210104	Урамшуулал	280,678,010.00	304,217,031.00
210105	Гэрээт ажлын хөлс	220,438,370.54	206,268,587.21
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	498,152,449.92	531,690,694.99
210201	Тэтгэврийн даатгалын зардал	336,948,531.82	364,510,700.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	38,987,741.31	42,830,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	34,388,405.85	21,608,200.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	16,699,689.31	21,327,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	71,128,081.63	81,413,294.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,181,429,251.94	1,542,201,864.36
210301	Гэрэл, цахилгаан	298,979,303.15	404,764,462.48
210302	Түлш, халаалт	636,197,620.92	964,180,977.88
210303	Цэвэр, бохир ус	246,252,327.87	173,256,424.00
2104	Хангамж, бараа материалын зардал	515,751,544.77	507,678,838.16
210401	Бичиг хэрэг	35,984,684.00	10,683,188.00
210402	Тээвэр, шатахуун	211,524,994.00	157,720,708.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,702,136.17	17,709,154.82
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,225,218.00	15,619,041.76
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	124,620,937.00	144,396,726.00
210408	Бараа материал акталсны зардал	120,693,575.60	161,550,019.58
2105	Нормативт зардал	2,262,771,652.12	2,142,935,129.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,585,807.69	5,584,765.35
210502	Хоол, хүнс	2,193,813,669.43	2,133,469,854.55
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,372,175.00	3,880,510.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	157,728,212.00	155,566,966.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,288,500.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	17,773,400.00
210604	Урсгал засвар	152,439,712.00	137,793,566.00
2107	Томилолт, зочны зардал	12,104,900.00	-
210701	Гадаад албан томилолт	12,104,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,337,333.67	81,139,823.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,200,201.05	36,743,896.96
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,500,000.00	6,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,133,540.00	22,719,890.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,486,500.00	4,045,768.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	103,000.00	209,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,914,092.62	10,921,268.09
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,335,576,182.34	1,819,868,029.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	372,556,235.50	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	77,905,066.00	38,879,280.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	885,114,880.84	1,780,988,749.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	174,206,179.93	87,228,561.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	14,121,081.56

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	14,121,081.56
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	14,121,081.56
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	14,121,081.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,890,380.00	69,382,370.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,272,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	24,299,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,750,380.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,140,000.00	41,810,670.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	98,315,799.93	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,920,199.93	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	395,600.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,725,110.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,725,110.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	9,859,847,656.67	378,580,262.91
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,142,763.13	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	1,142,763.13	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-1,142,763.13	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	9,858,704,893.54	378,580,262.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	11,223,422,686.38	10,668,890,728.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,541,744,825.38	10,668,890,728.12
120	Нийтлэг татварын бус орлого	6,541,744,825.38	7,071,715,217.12
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,541,744,825.38	7,071,715,217.12
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,367,738,225.38	6,871,047,717.12
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	174,006,600.00	200,667,500.00
122	Тусламжийн орлого	-	3,597,175,511.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	3,597,175,511.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	3,221,486,400.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	3,221,486,400.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	375,689,111.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	39,020,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	336,669,111.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,681,677,861.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,025,056,700.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,025,056,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,656,621,161.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	411,737,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,244,884,161.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,900,840,092.78	10,311,295,940.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,900,840,092.78	10,311,295,940.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,389,064,801.85	10,133,782,046.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,892,170,227.69	4,574,667,199.40
210101	Үндсэн цалин	1,826,580,247.01	1,965,047,231.99
210102	Нэмэгдэл	1,400,840,780.68	1,149,113,162.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	407,398,000.00	875,513,700.00
210104	Урамшуулал	257,351,200.00	584,993,105.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	466,661,929.00	535,660,600.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	317,030,369.93	364,510,700.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	37,332,900.00	42,830,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	29,866,400.00	21,608,200.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	7,766,529.07	21,327,800.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	74,665,730.00	85,383,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,196,804,962.32	1,755,871,084.48
210301	Гэрэл, цахилгаан	298,979,303.15	395,084,462.48
210302	Түлш, халаалт	650,303,331.30	1,187,530,198.00
210303	Цэвэр, бохир ус	247,522,327.87	173,256,424.00
2104	Хангамж, бараа материалын зардал	446,554,016.17	347,089,876.58
210401	Бичиг хэрэг	13,210,000.00	10,960,850.00
210402	Тээвэр, шатахуун	238,630,454.00	160,443,000.00

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,702,136.17	17,709,154.82
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,820,468.00	21,226,041.76
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	172,190,958.00	136,750,830.00
2105	Нормативт зардал	2,522,727,043.00	2,578,165,924.05
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,469,200.00	7,531,515.99
210502	Хоол, хүнс	2,295,011,343.00	2,320,609,008.06
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	225,246,500.00	250,025,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	271,932,754.00	183,065,964.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,673,772.00	2,485,000.00
210602	Тавилга	340,000.00	2,179,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	23,023,400.00
210604	Урсгал засвар	240,918,982.00	155,378,564.00
2107	Томилолт, зочны зардал	12,104,900.00	-
210701	Гадаад албан томилолт	12,104,900.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,731,084.67	93,636,023.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,086,761.00	36,259,062.58
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,500,000.00	6,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,885,500.00	22,504,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,486,500.00	4,045,768.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	103,000.00	209,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,669,323.67	24,117,292.47
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	492,377,885.00	65,625,375.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	384,939,411.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	107,438,474.00	65,625,375.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	511,775,290.93	177,513,893.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	103,546,413.56
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	103,546,413.56
213111	Төрийн сангаас харъяа төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн зардал	-	-
2131114	Нэмэлт санхүүжилтийн дансны өглөгт тооцох өмнөх оны төвлөрүүлэх шилжүүлгийн буцаалтын зардал	-	-
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	103,546,413.56
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	14,121,081.56
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	48,670,000.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	40,755,332.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	76,790,380.00	70,242,370.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	3,272,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,750,380.00	24,299,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,040,000.00	42,670,670.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	434,984,910.93	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,920,199.93	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	337,064,711.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	3,725,110.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,725,110.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,322,582,593.60	357,594,788.00

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,286,582,593.60	393,594,788.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,286,582,593.60	393,594,788.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,286,582,593.60	393,594,788.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,286,582,593.60	393,594,788.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,286,582,593.60)	(393,594,788.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	36,000,000.00	(36,000,000.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	36,000,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	36,000,000.00	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	Данс	511	51,300	51210+51220	
C01	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,207,582,556.84	11,607,163,646.06	(3,981,625,472.97)	13,833,120,729.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,207,582,556.84	11,607,163,646.06	(3,981,625,472.97)	13,833,120,729.93
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	9,858,704,893.54	9,858,704,893.54
C08	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,207,582,556.84	11,607,163,646.06	5,877,079,420.57	23,691,825,623.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,207,582,556.84	11,607,163,646.06	5,877,079,420.57	23,691,825,623.47
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	378,580,262.91	378,580,262.91
D09	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,207,582,556.84	11,607,163,646.06	6,255,659,683.48	24,070,405,886.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,264,945,900.00	10,279,080,535.56	14,134,635.56	100.1
12	Татварын бус орлого	10,264,945,900.00	10,279,080,535.56	14,134,635.56	100.1
120	Нийтлэг татварын бус орлого	7,009,892,900.00	7,071,715,217.12	61,822,317.12	100.9
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	6,835,886,300.00	6,871,047,717.12	35,161,417.12	100.5
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	174,006,600.00	200,667,500.00	26,660,900.00	115.3
122	Тусламжийн орлого	3,255,053,000.00	3,207,365,318.44	(47,687,681.56)	98.5
122005	Төсвөөс санхүүжих	3,255,053,000.00	3,207,365,318.44	(47,687,681.56)	98.5
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,264,945,900.00	10,230,410,535.56	(34,535,364.44)	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,264,945,900.00	10,230,410,535.56	(34,535,364.44)	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,234,368,200.00	10,201,838,835.56	(32,529,364.44)	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,574,667,200.00	4,574,667,199.40	(0.60)	100.0
210101	Үндсэн цалин	1,979,150,200.00	1,965,047,231.99	(14,102,968.01)	99.3
210102	Нэмэгдэл	1,148,772,800.00	1,149,113,162.16	340,362.16	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	875,513,700.00	875,513,700.00	-	100.0
210104	Урамшуулал	571,230,500.00	584,993,105.25	13,762,605.25	102.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	535,660,600.00	535,660,600.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	364,510,700.00	364,510,700.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	42,830,700.00	42,830,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,608,200.00	21,608,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	21,327,800.00	21,327,800.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	85,383,200.00	85,383,200.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,756,016,000.00	1,755,871,084.48	(144,915.52)	100.0
210301	Гэрэл, цахилгаан	395,173,800.00	395,084,462.48	(89,337.52)	100.0
210302	Түлш, халаалт	1,187,578,400.00	1,187,530,198.00	(48,202.00)	100.0
210303	Цэвэр, бохир ус	173,263,800.00	173,256,424.00	(7,376.00)	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	359,619,100.00	356,417,376.58	(3,201,723.42)	99.1
210401	Бичиг хэрэг	10,968,400.00	10,960,850.00	(7,550.00)	99.9
210402	Тээвэр, шатахуун	156,256,500.00	156,123,000.00	(133,500.00)	99.9

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,709,900.00	17,709,154.82	(745.18)	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	24,273,200.00	21,226,041.76	(3,047,158.24)	87.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	150,411,100.00	150,398,330.00	(12,770.00)	100.0
2105	Нормативт зардал	2,546,161,800.00	2,546,161,704.05	(95.95)	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,976,000.00	7,531,515.99	(1,444,484.01)	83.9
210502	Хоол, хүнс	2,287,160,400.00	2,288,604,788.06	1,444,388.06	100.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250,025,400.00	250,025,400.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	256,902,500.00	256,585,473.00	(317,027.00)	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	46,512,800.00	46,512,800.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	23,023,400.00	23,023,400.00	-	100.0
210604	Урсгал засвар	187,366,300.00	187,049,273.00	(317,027.00)	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	135,392,100.00	109,126,023.05	(26,266,076.95)	80.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,630,500.00	36,259,062.58	(21,371,437.42)	62.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,565,700.00	6,500,000.00	(65,700.00)	99.0
210803	Даатгалын үйлчилгээ	22,505,500.00	22,504,900.00	(600.00)	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	6,050,600.00	4,045,768.00	(2,004,832.00)	66.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	291,600.00	209,000.00	(82,600.00)	71.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,348,200.00	39,607,292.47	(2,740,907.53)	93.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,948,900.00	67,349,375.00	(2,599,525.00)	96.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	69,948,900.00	67,349,375.00	(2,599,525.00)	96.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,577,700.00	28,571,700.00	(2,006,000.00)	93.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,577,700.00	28,571,700.00	(2,006,000.00)	93.4
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,278,000.00	3,272,000.00	(2,006,000.00)	62.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,299,700.00	24,299,700.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	48,670,000.00	48,670,000.00	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(48,670,000.00)	(48,670,000.00)	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(48,670,000.00)	(48,670,000.00)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	36,000,000.00	36,000,000.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	36,000,000.00	36,000,000.00	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	279	278	(1)	99.6
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	142	138	(4)	97.2
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	85	84	(1)	98.8
620003	Үйлчлэх ажилтан	56	53	(3)	94.6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	135	138	3	102.2
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	18	17	(1)	94.4
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	0	(1)	0.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	116	121	5	104.3
66	НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	1	1	-	100.0
660001	Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	1	1	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	1. Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	375,689,111.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	375,689,111.00
122	Тусламжийн орлого	-	375,689,111.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	375,689,111.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	375,689,111.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	39,020,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	336,669,111.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	334,933,779.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	334,933,779.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	318,733,779.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,320,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	4,320,000.00
2105	Нормативт зардал	-	25,200,000.00
210502	Хоол, хүнс	-	25,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	289,213,779.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	23,103,400.00
210602	Тавилга	-	21,526,600.00
210604	Урсгал засвар	-	244,583,779.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	16,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	16,200,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	40,755,332.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(40,755,332.00)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(40,755,332.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллагын дүрмэнд “Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор нь хүүхэд, өсвөр үеийгзасах хүлээн авч, тэдний амрах, хөгжих ая тухтай орчин, хөгжлийн хөтөлбөрөөр үйлчлэн, тэдний хөгжлийг дэмжих, хүүхдийн зуслан, хөгжлийн ордон, төвүүдийг хөгжлийн хөтөлбөрийн арга зүйгээр хангах чиг үүргийг гүйцэтгэдэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн үйлчилгээний байгууллага юм” гэж тодорхойлсон байна.

Тус цогцолборын үйл ажиллагааны зорилго нь Улс үндэстний хүүхдийн хөгжлийг дэмжиж, амьдралын сорилтод бэлтгэх хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлчлүүлэгч бүрийг эрүүл, аюулгүй орчинд амарч, хөгжих боломжийг бүрдүүлэн үйлчлэх, хөгжлийн хөтөлбөрийн арга зүйг дэлгэрүүлэхэд оршино.

Цогцолбор нь тайлант онд дараах 7 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйлчлүүлэгчдийн хүлээлтэд нийцсэн үйлчилгээг үзүүлэх;
- Хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийн онцлогт тохирсон иж бүрэн орчин бүрдүүлэх;
- Салбарын байгууллагуудыг арга зүйгээр хангах ;
- Байгууллагын санхүүгийн менежментийг сайжруулах;
- Байгууллагын үйл ажиллагаанд технологийн шинэчлэл хийх;
- Чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх;
- Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус цогцолбор нь үйл ажиллагаандаа Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколууд, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбор нь Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 312,085.6 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	36,000.0		(36,000.0)
Авлага	548,859.7	358,090.6	(190,769.1)
Бараа материал	1,086,639.6	1,461,631.5	374,991.9
Үндсэн хөрөнгө	22,185,280.9	22,349,143.7	163,862.8
Нийт хөрөнгө	23,856,780.2	24,168,865.8	312,085.6
Өр төлбөр	164,954.6	98,459.9	(66,494.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	23,691,825.6	24,070,405.9	378,580.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	23,856,780.2	24,168,865.8	312,085.6

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 358,090.6 мянган төгрөг болж, 190,769.1 мянган төгрөгөөр буурсан нь ажиллагчдтай холбогдсон авлага 881.5 мянган төгрөг, төлбөртэй үйлчилгээний авлага 14,161.5 мянган төгрөг, бусад авлага 41,431.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, татаас санхүүжилтийн авлага 247,243.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 1,461,631.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 374,991.9 мянган төгрөгөөр өссөн нь нүүрс, миндингийн үлдэгдэл 318,508.8 мянган төгрөгөөр, ажлын хувцас, зөөлөн эдлэл, лега тоглоомын үлдэгдэл 56,483.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөө үзүүлжээ.

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 22,349,143.7 мянган төгрөг болж, 163,862.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 152,121.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр 1,447,856.0 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны давсан орлогос 241,473.8 мянган төгрөгийн, нийт 1,689,329.8 мянган төгрөгийн барилгын их засвар хийж, барилгын сайжруултыг бүртгэсэн, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2025 оны А/178 дугаар тушаалаар 97,900.8 мянган төгрөгийн компьютер шилжүүлэн авч, өмнөх аудитын зөвлөмжийн дагуу 5,500.0 мянган төгрөгийн программыг бүртгэн авч нийт 1,944,851.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, ТӨБЗГ-ын 2025 оны 278 тоот тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 237,197.3 мянган төгрөгийн хөрөнгө актлан данснаас хасч, 1,780,988.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 98,459.9 мянган төгрөг болж 66,494.7 мянган төгрөгөөр буурсан нь ажилчидтай холбогдсон өглөг 65,484.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын өглөг 11,049.1 мянган төгрөгөөр, бусад өглөг 66,026.6 мянган төгрөгөөр тус тус буурч, урьдчилж орсон орлого 76,065.1 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцооны дүн 24,070,405.9 мянган төгрөг болж 378,580.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн: Тус цогцолбор нь тайлант онд 1,906.5 мянган төгрөгийн номын сангийн программ худалдан авч, 21,733.0 мянган төгрөгөөр байгууллагын цахим хуудасанд хөгжүүлэлт хийлгэж биет бус хөрөнгөөр бүртгэсэн байна. Мөн өмнөх аудитын зөвлөмжийн дагуу 5,500.0 мянган төгрөгийн VR /хөтөлбөр/-ийг бүртгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлдээ 2,200.0 мянган төгрөгийн үнэтэй Санхүүгийн тооцоолох ХХК-ийн Acoulos accounting system 4.0 санхүүгийн программ ашиглаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,809,667.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 6,295,627.6 мянган төгрөг, нийт 12,105,294.9 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тоцон төлөвлөж, саналыг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 1,168,983.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 178,292.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 242,956.1 мянган төгрөг, нормативт зардлыг 90,102.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 44,011.0 мянган төгрөг, томилолтын зардлыг 17,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 10,573.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 464,100.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 24,654.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 114,615.0 мянга, мянган төгрөгөөр нэмэгдүүлж 9,979,236.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 285,709.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 зорилтын 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,255,053.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 6,835,886.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 174,006.6 мянган төгрөг, нийт 10,264,945.9 мянган төгрөг бүрдүүлэхээр байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,207,365.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 6,871,047.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 200,667.5 мянган төгрөг, нийт 10,279,080.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 48,670.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, авлага үүсгэсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,230,410.5 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 11,157.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлыг 2,006.0 мянган төгрөгөөр, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлыг 21,371.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	72207 Хүүхдийн хөгжил, хамгаалал	10,264,945.9	10,230,410.5	34,535.4	99.7
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	9,929,690.4	9,918,532.5	11,157.9	99.9
1.2	80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	247,047.3	247,047.3	-	100.0
1.3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	30,577.7	28,571.7	2,006.0	93.4
1.4	81569- Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	57,630.5	36,259.1	21,371.4	62.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/18 дугаар тушаалаар Цогцолборын 2025 оны орон тоо бүтцийг удирдах 3, гүйцэтгэх 56, үйлчлэх 97, нийт 156 ажилтантай байхаар баталсныг Монгол Улсын Их хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийг үндэслэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны А/196 дугаар тушаалаар 142 ажилтантай байхаар шинэчлэн баталсан байна. Тайлант онд цалингийн зардалд 4,574,667.2 мянган төгрөгийн төсөв баталсныг бүрэн зарцуулсан байна.
- Цогцолборын ерөнхий захирлын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны А/06 тоот тушаалаар ажлын нэг өдөрт хоолонд 22.0 мянган төгрөг, унаанд 3.0 мянган төгрөгийн хөнгөлөлт олгохоор баталжээ. Үүний дагуу тайлант онд ажилчдад нийт 795,246.5 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлт олгосон байна.

- Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс болж ажлаас чөлөөлөгдсөн 2 ажилтанд Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 184/шш2020/03354, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 184/шш2021/00116 тоот шийдвэрүүдийн дагуу байгууллагаас 11,150.4 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон зөрчилд 2022, 2023, 2024 онуудын аудитаар албан шаардлага өгсөн ч хэрэгжээгүй байна.
- Тайлант онд хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр сургалт, семинар, зохион байгуулж нийт 8,494.0 мянган төгрөгийн зардал гарсан байна Зуны улиралд шинээр орсон ажилтнуудад зориулсан сургалтад 84 ажилтан, ISO 14001 Байгаль орчны стандартын сургалтад 5 ажилтан, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй сургалтад ХАБЭА хариуцсан ажилтан албадын дарга нар, бүлгийн удирдагчдын чадавхижуулах 8 өдрийн 64 цагийн танхмын сургалтад 30 ажилтан тус тус хамрагдсан байна.
- Тайлант онд гадаад томилот, арга хэмжээний зардал, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний төлбөртэй холбоотой зардлууд гараагүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цогцолборын ерөнхий захирлын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны А/03 тоот тушаалаар 3,457,288.1 мянган төгрөгийн 7 нэрийн бараа, ажил үйлчилгээг худалдан авах төлөвлөгөөг, 2025 оны 03 дугаар сарын 19-ний А/39 тоот тушаалаар 307,050.8 мянган төгрөгийн 4 нэрийн бараа, ажил үйлчилгээг худалдан авах нэмэлт төлөвлөгөөг тус тус баталсан байна. Тайлант онд худалдаан авах нийт 3,764,338.9 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар гүйцэтгэхээр төлөвлөжээ.

Төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, нийт 12 оролцогчийг шалгаруулан 3,008,135.5 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, авлага барагдуулах, үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг, гэрээний хэрэгжилт, хөрөнгийн бүртгэлтэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Аккаунт траст аудит” ХХК-ийн ахлах аудитор Ч.Замбага, аудитор Р.Цогзолмаа, туслах аудитор П.Саранчимэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал П.Наранцэцэг, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэтуяа нар, дараагийн шатны хяналтыг Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Номингуа, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Олон улсын хүүхдийн найрамдал цогцолборын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

